

**БАТЛАВ.
ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН САЙД**



Х.НЯМБААТАР

ПАТЕНТЫН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг.Хуулийн төслийг боловсруулах болсон үндэслэл, шаардлага

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлд Монгол Улсын иргэн баталгаатай эдлэх эрх, эрх чөлөөг заасан бөгөөд тус зүйлийн 1 дэх хэсгийн 8-д “соёл, урлаг, шинжлэх ухааны үйл ажиллагаа явуулах, бүтээл туурвих, үр шимийг нь хүртэх эрхтэй. Зохиогч, шинэ бүтээл, нээлтийн эрхийг хуулиар хамгаална.” гэж, Тавдугаар зүйлийн 2-т “төр нь нийтийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч, өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална” гэж, мөн зүйлийн 3-т “Өмчлөгчийн эрхийг гагцхүү хуульд заасан үндэслэлээр хязгаарлаж болно” гэж, Долдугаар зүйлийн 2-т “Иргэний туурвисан оюуны үнэт зүйл бол зохиогчийн өмч, үндэсний баялаг мөн” гэж тус тус заасан.

Үүний дагуу аж үйлдвэрийн өмчийн үндсэн объект болох шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварыг бүртгэх, патент болон гэрчилгээ эзэмшигчийн өмчлөх эрхийг баталгаажуулах, тэдгээрийг ашиглахтай холбоотой харилцааг зохицуулах, улмаар эдийн засгийн эргэлтэд оруулах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор Патентын тухай бие даасан хуулийг 1993 онд баталсан. Тус хуульд 1996, 1999 онд тус тус нэмэлт, өөрчлөлт оруулсан бөгөөд нийгэм, эдийн засгийн харилцааны шинэчлэлтэй уялдуулан 2006 онд шинэчлэн найруулсан байна.

Түүнчлэн 2020 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр Оюуны өмчийн тухай хууль батлагдсан бөгөөд тус хуулийг 2020 оны 12 дугаар сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөхөөр заасан. Хуулиуд хооронд зөрчил, хийдэл үүсгэхгүй байх үүднээс 2006 онд батлагдсан Патентын тухай хуулийг Оюуны өмчийн тухай хуулийн үзэл баримтлал, зохицуулалтад нийцүүлэн шинэчлэх шаардлагатай юм.

Техник, технологийн өндөр хөгжлийг дагаад шинэ бүтээл, ашигтай загвар, бүтээгдэхүүний загварын шийдлээ хамгаалуулах, ашиглах сонирхол хурдацтай өсөж байна. Түүнчлэн шинийг бүтээгч, үйлдвэрлэл эрхлэгчид мэдлэг, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэхийг эрмэлзэхээс гадна гадаадын зах зээлд гаргах, бизнесээ өргөжүүлэх асуудлыг ихээхэн анхаарах болжээ.

Улсын хэмжээнд патентын мэдүүлгийн тоо тогтвортой нэмэгдэж байгаа бөгөөд мэдүүлгийн ихэнх нь патент, гэрчилгээ олгох шалгуурыг хангаж байна. Тухайлбал, 2010-2019 онд шинэ бүтээлийн 2111 мэдүүлгийн 70%, бүтээгдэхүүний загварын 2974 мэдүүлгийн 94%-д патент олгохоор, ашигтай загварын 1797 мэдүүлгийн 75%-д нь

гэрчилгээ олгохоор шийдвэрлэсэн байна.¹ Нийгэм, эдийн засгийн хөгжлийн хувьд дэлхийд тэргүүлэх байр суурь эзэлж байгаа улс орнууд байгалийн баялагт бус мэдлэгт тулгуурласан эдийн засгийг бий болгохоор эрмэлзэж байна. Үүний тод жишээ нь 2018 оны байдлаар Патентын Хамтын Ажиллагааны Гэрээ (ПХАГ)-ний дагуу Америкийн Нэгдсэн Улсаас 56,142, Япон Улсаас 49,702, БНХАУ-аас 53,345, Европийн Патентын Байгууллагаас 35,309, Солонгос Улсаас 17,014 мэдүүлэг гаргасан байна.² Харин Монгол Улсын хувьд 2008-2018 онд ПХАГ-ний дагуу нийт 16 олон улсын мэдүүлэг гаргажээ.³

Монгол Улс патентын бие даасан хуультай хэдий ч хуулиар зохицуулах шаардлагатай харилцааг зохицуулалтгүй орхигдуулсан, хуулийн зүйл, заалтууд өөр хоорондоо зөрчилтэй, түүнчлэн патент, гэрчилгээ олгох үйл ажиллагаа нь Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ хэлэлцээр, олон улсад тогтсон практикт нийцээгүй зэрэг асуудалтай байна. Тухайлбал, шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загвар гэсэн тус тусын онцлог бүхий бүтээлүүдийн ялгааг үл харгалзан хуульд нэг стандартаар зохицуулсан, мэдүүлэг гаргах, түүнд шүүлт хийхтэй холбоотой зохицуулалт олон улсын практикт нийцтэй бус, түүнчлэн патентыг албадан лицензээр ашиглах асуудал тодорхой бус, оюуны бүтээл бүтээгчдийг дэмжсэн санхүүгийн дэмжлэг, татвар, хураамжийн хөнгөлөлтийн бодлого байхгүй, патенттай холбоотой олон улсын мэдүүлэг гаргах, хүлээн авах зохицуулалт нь Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ хэлэлцээрт заасан стандарт, шаардлагыг хангахгүй байна.⁴

Оюуны өмчийн маргаан шийдвэрлэх комисст ирсэн шинэ бүтээл, бүтээгдэхүүний загварын патент, ашигтай загварын гэрчилгээний талаарх өргөдлийн 80%-ийг “шинэ, тухайн үеийн түвшингээс давуутай”, “нийтэд илэрхий болсон, нэвтэрч ашиглагдсан, хэвлэн нийтлэгдсэн” гэсэн нэр томъёоны ойлголтуудтай холбоотой маргаан эзэлж байгаа⁵ тул нэр томъёоны тодорхойлолтыг сайжруулах шаардлагатай байна

Монгол Улс нь оюуны өмчийг хамгаалах чиглэлээр 20 орчим олон улсын гэрээнд нэгдэн орсон байдаг.⁶ Эдгээрийн нэг нь 2014 онд нэгдэн орсон Биологийн олон янз байдлын тухай конвенцийн Генетик нөөц ашигласнаас үүдэх үр ашгийг шударга эрх тэгш хуваарилах тухай Нагояагийн протокол⁷ юм. Тус протоколоор генетикийн нөөц дээр тулгуурлан бүтээсэн шийдлийн хувьд генетикийн нөөцийн гарал үүсэл, эх сурвалж, урьдчилсан мэдэгдэл зэргийг мэдүүлэгт хавсаргах шаардлага тавигддаг ч энэ талаар Патентын тухай хуульд тусгайлсан зохицуулалт байхгүй байна.

Түүнчлэн Патентын Хамтын Ажиллагааны Гэрээний (ПХАГ) дагуу олон улсын мэдүүлгийн огнооноос хойш 21-31 сарын дараа тухайн мэдүүлэг Монгол Улсад ирдэг,

¹Оюуны Өмчийн Газрын Аж үйлдвэрийн өмчийн эрхийн хэлтсийн тоон мэдээлэл. 2020 оны 07 дугаар сар.

²Дэлхийн Оюуны Өмчийн Байгууллагын албан ёсны цахим хуудас. <https://patentscope.wipo.int/search/>

³Дэлхийн Оюуны Өмчийн байгууллагын албан ёсны цахим хуудас. <https://patentscope.wipo.int/search/>

⁴Патентын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ. ХЗДХЯ, ХЗҮХ.2017 он

⁵Оюуны өмчийн маргаан шийдвэрлэх комиссын шийдвэрээс хийсэн шүүлт. /2012-2016он/. Судлаач Д.Нэргүй.

⁶Гадаад харилцааны яамны албан ёсны цахим хуудас. <http://www.mfa.gov.mn>

⁷Монгол улс 2013 оны 5 сард соёрхон баталж, 2014 оны 10 дугаар сард албан ёсны гишүүн болсон.

гэтэл патент олгох эсэхийг анх мэдүүлсэн огнооноос 9-12 сарын дотор байхаар хуульчилсан нь зарчмын хувьд зөрчилдөөн үүсгэдгийг оновчтой зохицуулах шаардлагатай байна. Үүнээс гадна патент олгох ажиллагааны үндсэн ажиллагаа болох “хайлт”-ыг зохицуулаагүй орхигдуулснаас ижил төстэй бүтээлийг олж илрүүлэх ажиллагаа орхигдож, мөн чанарын шүүлт бодитой, үр дүнтэй хийгдэж чадахгүйд хүрдэг.

Иймд эдгээр нөхцөлийг харгалзан Монгол Улсын Их Хурлын 2017 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн 11 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 141-д “Патентын тухай хуульд Дэлхийн оюуны өмчийн байгууллагаас өгсөн саналыг үндэслэн патентын эрхийн хамгаалалтыг дэлхий дахины чиг хандлага, Дэлхийн оюуны өмчийн байгууллагын гэрээ, хэлэлцээрт нийцүүлэн боловсронгуй болгох” гэж тусгасан.

Дээр дурдсан хууль зүйн үндэслэл, практик шаардлагын хүрээнд хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахад хуулийн үндсэн бүтцэд өөрчлөлт орж, 2-3 бүлэг зохицуулалт шинээр нэмэгдэхээр байгаа⁸ тул Хууль тогтоомжийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.2-т заасны дагуу Патентын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулна.

Хоёр.Хуулийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Патентын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл нь нийт 9 бүлэгтэй байна. Үүнд:

- 1.Хуулийн төслийн нэгдүгээр бүлэгт нийтлэг үндэслэл;
- 2.Хуулийн төслийн хоёрдугаар бүлэгт шинэ бүтээл, ашигтай загварын патентын эрхийн хамгаалалт;
- 3.Хуулийн төслийн гуравдугаар бүлэгт шинэ бүтээл, ашигтай загварын патентын мэдүүлэг, түүнд шүүлт хийх;
- 4.Хуулийн төслийн дөрөвдүгээр бүлэгт бүтээгдэхүүний загварын патентын эрхийн хамгаалалт;
- 5.Хуулийн төслийн тавдугаар бүлэгт патент олгох, патентын хүчинтэй хугацаа, патентын хураамж;
- 6.Хуулийн төслийн зургадугаар бүлэгт патентын олон улсын мэдүүлэг;
- 7.Хуулийн төслийн долоодугаар бүлэгт патентын эрх, патент эзэмшигчийн эрхийг хамгаалах;
- 8.Хуулийн төслийн наймдугаар бүлэгт оюуны өмчийн байцаагч, маргаан шийдвэрлэх зөвлөл;
- 9.Хуулийн төслийн есдүгээр бүлэгт бусад зүйлийн талаар тус тус зохицуулна.

⁸“Хуулийн хэрэгжилтийн үр нөлөөг дээшлүүлэхийн тулд шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах шаардлага гарч болзошгүй.” хэмээн дүгнэсэн.Патентын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ. ХЗДХЯ, ХЗҮХ.2017 он

Хуулийн төслөөр Патентын тухай хуулийг дараахь хүрээнд шинэчлэн найруулна:

1.Шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар болон ашигтай загварын шийдлийг бүртгэхээс гадна тухайн бүтээлийн онцгой эрхтэй холбоотой асуудлыг зохицуулах, лицензийн гэрээний асуудлыг зохицуулна.

2.Хуулийн зарим нэр томъёоны (шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, шинэ бүтээлийн түвшин агуулсан байдал, зохиогч зэрэг) тодорхойлолт нь оновчгүй, эсхүл давхардсан агуулгаар тодорхойлогдсоныг бусад хууль тогтоомж, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээтэй нийцүүлэн шинэчилнэ.

3.Аж үйлдвэрийн өмчийн эрхийн гурван үндсэн объект болох шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварыг ялгаж, тус тусын онцлогт нийцсэн тусгай бүлгээр зохицуулна. Ашигтай загварын шийдэлд хамаарах зүйлийн хүрээг олон улсын жишигт нийцүүлэн өөрчилж, патент олгох ажиллагааг богино хугацаанд хийнэ.

4.“Мэдүүлгийн бүрдлийг хянах” болон “мэдүүлгийн бүрдлийн шаардлагад шүүлт хийх” ажиллагааны ялгааг тодруулж, “хайлт” хийх ажиллагаатай холбоотой зохицуулалтыг нарийвчлан зохицуулна.

5.Мэдүүлэгт мөн чанарын шүүлт хийх, шинжээчийн дүгнэлт гаргах, патент олгох эсэхийг шийдвэрлэх хугацааг хуульд хэт богино тогтоосон, мөн мэдүүлгийн бүрдлийг хянах хугацааг эргэлзээтэй байдлаар тогтоосныг өөрчилж, хугацааг оновчтой тогтооно.

6.Патент олгох болон патент олгохоос татгалзах шийдвэрийг дахин хэлэлцэх, мөн шийдвэр гаргах үндэслэлийг тодорхой зааж, энэхүү шийдвэрт мэдүүлэг гаргагчаас гомдол гаргах эрхээ хэрэгжүүлэх, түүнчлэн мэдүүлэг гаргагч мэдүүлэгт нэмэлт, засвар хийх боломж олгоно.

7.Шинийг санаачлагч, мэдүүлэг гаргагчид хугацааны хөнгөлөлт эдлүүлэх боломжийг бүрдүүлнэ.

8.Шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварын мэдүүлгийг цахим хэлбэрээр гаргах зохицуулалтыг шинэчлэх, мөн шүүлт хийлгэх хүсэлт гаргах, шинэ бүтээл, ашигтай загвар, бүтээгдэхүүний загварын бүтээлийг нийтэд мэдээлэхтэй холбоотой зохицуулалтыг нарийвчлан зохицуулна.

9.Шинэ бүтээл, ашигтай загварыг бүртгэснээс хойш бий болох харилцаа зохицуулалтгүй орхигдож байгааг анхаарч, патент эзэмшигчийн мэдээлэл, бүтээлийн томъёололд өөрчлөлт оруулах асуудлыг зохицуулна.

10.Патентын эрх зүйн зохицуулалтыг Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээний холбогдох зохицуулалттай нийцүүлнэ. Энэ хүрээнд олон улсын мэдүүлэг гаргах, хүлээн авах, шүүлт хийх, олон улсын болон бусад улсын хайлт, шүүлтийн тайланг ашиглах, хүлээн зөвшөөрөх зохицуулалтыг Патентын хамтын ажиллагааны гэрээнд, “үзэсгэлэнгийн давамгайлах огноо”-ны зохицуулалтыг Аж үйлдвэрийг

хамгаалах Парисын конвенцод⁹, мөн шинэ бүтээл, бүтээгдэхүүний загварт хугацааны хөнгөлөлт үзүүлэх асуудал, патент олгох шалгуурыг олон улсын стандартад, шинэ бүтээлд тооцохгүй зүйлсийн шалгуурыг Худалдаанд хамаарах оюуны өмчийн эрхийн хэлэлцээрт¹⁰, бүтээгдэхүүний загварын хадгалалт, хамгаалалтын болон хүчинтэй байх хугацааны талаарх зохицуулалтыг Бүтээгдэхүүний загварын олон улсын бүртгэлийн тухай Гаагийн хэлэлцээрт¹¹ тус тус нийцүүлэн зохицуулна.

11.Оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн оролцоог нэмэгдүүлэх шаардлагад тулгуурлан түүний эрх хэмжээ, чиг үүрэгтэй холбоотой зохицуулалтыг тусгана.

12.Зөрчил, гэмт хэрэгт хамаарахгүй патентын эрхийн харилцаатай холбоотой маргаан шийдвэрлэх журмыг тодорхой тусгана.

13.Шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварын мэдүүлэг гаргах, бүртгэхтэй холбоотой дүрэм, журам батлах эрх хэмжээг холбогдох захиргааны байгууллагад олгоно.

Гурав.Хууль тогтоомж батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

Патентын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл батлагдсанаар өнөөгийн практикт гарч буй эрсдэл буурч, хууль нэг мөр хэрэгжих баталгаа хангагдана. Түүнчлэн энэ чиглэлээр төрийн үйлчилгээний хүртээмж, ил тод байдал, хариуцлага сайжирч, шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварын мэдүүлэг гаргах, түүнд шүүлт хийх ажиллагаа илүү тодорхой болсноор мэдүүлэг гаргагчид учирдаг чирэгдэл багасна.

Мөн шинэ бүтээл, ашигтай загвар, бүтээгдэхүүний загвар нь патент, гэрчилгээ эзэмшигчийн амьжиргааны хэрэгсэл болж, эрх нь хамгаалагдсан бүтээлээ олон улсын зах зээлд нэвтрүүлэх зэргээр Монгол Улсын эдийн засагт эерэг нөлөө үзүүлэх нөхцөл бүрдэнэ.

Дөрөв.Уг хууль нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаарх санал

Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, Оюуны өмчийн тухай хууль болон бусад хуульд нийцүүлэн боловсруулна. Энэ хуулийн төсөлтэй холбогдуулан Патентын тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хууль, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гаалийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Оюуны өмчийн тухай

⁹ 1970 оны 5 дугаар сарын 19-ний өдөр хүчин төгөлдөр болсон.

¹⁰ 1997 оны 01 дүгээр сарын 29-ний өдөр хүчин төгөлдөр болсон

¹¹ 1984 оны 8 дугаар сарын 01-ний өдөр хүчин төгөлдөр болсон.

хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг тус тус боловсруулна.

--oOo--